



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/18/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn Аудитор: Утас: 70342716 Цахим хаяг:
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Будган сум, Будган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 246

танай _____ ны № _____ Т

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА
Д.АЛТАНШАГАЙ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол аймгийн ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн ЗДТГ нь жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 67981.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бараа материалын тооллого хийгээгүй.

Албан хаагчдын ашиглаж байгаа хөрөнгийн картаар тооллого хийгдсэн гэх боловч албан хаагчдын гарын үсэг дутуу, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаагүй.

Шатахууны орлого, зарлагын зарцуулалтыг санхүүгийн программд тайлагнадаг ч нярав сар, улирлаар шатахууны орлого, зарлагын нэгтгэсэн тайлан гаргадаггүй, 118091.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын жолоочийн тооцооны хуудас болон даргын цохолт дутуу, анхан шатны баримтын бүрдэлтийг бүрэн бүрдүүлж ажилладаггүй, архивын нэгж болгон үдэж цэгцлээгүй, шатахууны зардлыг тооцож олгохдоо тухайн авто машины нормоор тооцож олгоогүй 1476.0 мянган төгрөгөөр илүү олгосон.

Албан томилолтын зардлын хоногийг 1961.0, ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 509.8 мянган төгрөгийг тус тус илүү тооцож олгосон байна.

Нийт 122038.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" , НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." , 13 дугаар зүйлийн 7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд

006020263

тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын дүнгээс илүү илэрхийлэгдэж санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1 болон 8 дугаар зүйлийн 8.1 дэх зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд төсвийн хөрөнгөөр 128832.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 08 тоот тогтоолоор 1245797.2 мянган төгрөгийн өртөгтэй “Ахмадын өргөө”-ний барилгыг, 7000.0 мянган төгрөгийн Ниссан патрол суудлын автоамшиныг тус тус шилжүүлэн өгсөнийг орлого авч тайлагнасан байна.

Мөн аймгийн ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/72 тоот тушаалаар цаашид ашиглах боломжгүй болсон 93056.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийн үндсэн хөрөнгийг актлаж данс бүртгэлээс хасаж тайлагнажээ.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 45 зорилтын хүрээнд 159 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 158 ажил хэрэгжиж, огт хэрэгжээгүй 1 ажил дутуу, биелэлт 90.9 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгджээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>81,035,522.81</u>	<u>570,821,699.76</u>
33	АВЛАГА	11,113,333.05	502,839,940.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	2,060,915.00
335	Бусад авлага	11,113,333.05	500,779,025.00
3351	Байгууллагаас авах авлага	773,333.05	500,779,025.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,340,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69,922,189.76	67,981,759.76
351	Түүхий эд материал	9,318,000.00	9,318,000.00
35110	Тусгай зориулалттай материал	9,318,000.00	9,318,000.00
354	Хангамжийн материал	60,604,189.76	58,663,759.76
35410	Бичиг хэргийн материал	922,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	39,790,639.76	52,287,069.76
35440	Түлш, шатах тослох материал	490,000.00	849,690.00
35470	Бусад хангамжийн материал	19,401,550.00	5,527,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,562,386,547.50</u>	<u>7,398,813,923.95</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,562,386,547.50	7,398,813,923.95
391	Газар	135,278,000.00	135,278,000.00
392	Биет хөрөнгө	5,425,962,714.17	7,263,215,923.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,317,296,794.93	6,810,729,324.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-449,055,509.42	-478,060,851.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	491,000,000.00	432,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-229,294,444.56	-64,091,665.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	379,706,161.58	452,451,001.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	-241,352,195.26	-120,077,269.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	277,094,240.28	269,805,174.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-165,493,754.50	-80,757,230.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,327,770.00	59,327,770.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,266,348.88	-18,210,329.68
393	Биет бус хөрөнгө	1,145,833.33	320,000.00
39301	Програм хангамж	1,250,000.00	00.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-104,166.67	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,654,000.00	320,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-5,654,000.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,643,422,070.31</u>	<u>7,969,635,623.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>500,779,025.00</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	500,779,025.00
413	Өглөг	00.00	500,779,025.00
4136	Бусад өглөг	00.00	500,779,025.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	500,779,025.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,643,422,070.31	7,969,635,623.71
51	Засгийн газрын хувь оролцоо	5,643,422,070.31	7,468,856,598.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,104,006,679.64	1,104,006,679.64
51101	Өмч: - төрийн	135,278,000.00	135,278,000.00
51102	- хувийн	968,728,679.64	968,728,679.64
512	Хуримтлагдсан үр дүн	3,545,159,064.24	5,409,368,665.84
51210	Өмнөх үеийн үр дүн	3,545,159,064.24	3,583,934,137.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,825,434,528.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	994,256,326.43	955,481,253.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,643,422,070.31	7,969,635,623.71

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,037,543,319.00	7,804,861,289.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	287,856,071.00	1,962,586,272.78
120	Нийтлэг татварын бус орлого	287,856,071.00	1,962,586,272.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	287,856,071.00	1,962,586,272.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,177,105.00	10,538,622.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	278,678,966.00	1,952,047,650.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,749,687,248.00	5,842,275,017.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	357,229,748.00	2,698,112,117.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	27,108,000.00	2,141,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	182,234,708.00	476,207,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	147,887,040.00	80,905,017.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,392,457,500.00	3,144,162,900.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,392,457,500.00	3,144,162,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,404,071,346.64	5,953,504,761.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,404,071,346.64	5,953,504,761.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,021,111,413.47	5,672,490,166.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	930,303,370.00	1,039,479,394.00
210101	Үндсэн цалин	486,162,820.00	581,445,503.92
210102	Нэмэгдэл	219,096,571.69	187,909,956.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,098,268.31	37,673,800.12
210104	Урамшуулал	00.00	44,526,107.09
210105	Гэрээт ажлын хөлс	203,945,710.00	187,924,026.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,769,366.13	119,914,080.79
210201	Тэтгэврийн даатгал	77,284,140.07	85,410,737.04
210202	Тэтгэмжийн даатгал	8,320,495.28	8,348,202.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,584,355.82	6,151,571.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,519,563.52	1,897,179.91
210205	Эрүүл мэндийн даатгал	17,060,811.44	18,106,390.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,372,954.50	309,823,311.18
210301	Гэрэл, цахилгаан	10,525,904.50	12,297,131.28
210302	Түлш, халаалт	195,578,273.00	283,089,421.00
210303	Цэвэр, бохир ус	11,268,777.00	14,436,758.90
2104	Хангамж, бараа материалын зардал	97,504,692.85	121,404,080.06
210401	Бичиг хэрэг	13,087,910.00	15,172,000.00
210402	Тээвэр, шатахуун	49,630,000.00	83,640,369.94
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,071,672.85	14,696,880.12
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,027,200.00	3,948,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,882,910.00	3,946,130.00
210408	Бараа материал акталсны зардал	3,805,000.00	00.00
2105	Нормативт зардал	2,513,000.00	1,841,230.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,411,000.00	1,841,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	102,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,602,115.00	95,657,720.00
210604	Урсгал засвар	44,602,115.00	95,657,720.00
2107	Томилолт, зочны зардал	56,011,160.00	125,930,113.00
210701	Гадаад албан томилолт	00.00	40,394,100.00
210702	Дотоод албан томилолт	29,932,000.00	55,536,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	26,079,160.00	29,999,663.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	291,781,715.00	421,497,740.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	285,251,800.00	411,594,110.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,900,000.00	4,808,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	472,215.00	613,547.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,505,700.00	3,587,994.00
210807	Газрын төлбөр	520,000.00	762,089.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,270,253,039.99	3,436,942,497.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,001,776,934.48	2,919,124,016.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	73,638,376.00	288,947,806.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	194,837,729.51	228,870,674.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	382,959,933.17	281,014,594.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,080,055.00	115,515,775.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	60,000,000.00	46,613,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	22,818,198.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,800,200.00	20,125,332.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,279,855.00	25,958,945.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	296,879,878.17	165,498,819.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	296,879,878.17	165,498,819.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-366,528,027.64	1,851,356,528.23
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,980,931.89	25,921,999.83
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,980,931.89	25,921,999.83
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10,980,931.89	-25,921,999.83
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-377,508,959.53	1,825,434,528.40

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,363,864,353.00	5,852,813,630.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	614,177,105.00	10,538,622.00
120	Нийтлэг татварын бус орлого	614,177,105.00	10,538,622.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	614,177,105.00	10,538,622.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,177,105.00	10,538,622.00

1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	605,000,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,749,687,248.00	5,842,275,008.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	357,229,748.00	2,698,112,108.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	27,108,000.00	2,141,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	182,234,708.00	476,207,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	147,887,040.00	80,905,008.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,392,457,500.00	3,144,162,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,392,457,500.00	3,144,162,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,286,461,683.00	5,723,981,239.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,286,461,683.00	5,723,981,239.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,903,501,751.83	4,942,187,619.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	930,548,422.12	1,041,540,309.57
210101	Үндсэн цалин	484,871,683.99	583,486,819.49
210102	Нэмэгдэл	222,290,604.19	187,934,956.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,098,262.31	37,673,800.12
210104	Урамшуулал	00.00	44,526,107.09
210105	Гэрээт ажлын хөлс	202,287,871.63	187,918,626.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,297,647.18	119,914,080.79
210201	Тэтгэврийн даатгал	77,812,421.12	85,410,737.04
210202	Тэтгэмжийн даатгал	8,320,495.28	8,348,202.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,584,355.82	6,151,571.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,519,563.52	1,897,179.91
210205	Эрүүл мэндийн даатгал	17,060,811.44	18,106,390.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	217,372,954.50	309,823,311.18
210301	Гэрэл, цахилгаан	10,525,904.50	12,297,131.28
210302	Түлш, халаалт	195,578,273.00	283,089,421.00
210303	Цэвэр, бохир ус	11,268,777.00	14,436,758.90
2104	Хангамж, бараа материалын зардал	79,614,292.85	121,136,710.12
210401	Бичиг хэрэг	11,822,960.00	14,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	48,000,000.00	84,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,071,672.85	14,696,880.12
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,208,430.00	3,948,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,511,230.00	3,991,130.00
2105	Нормативт зардал	5,053,150.00	1,991,230.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,549,150.00	1,991,230.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,504,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,719,665.00	103,453,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	165,000.00	286,000.00
210604	Урсгал засвар	50,554,665.00	103,167,950.00
2107	Томилолт, зочны зардал	57,997,060.00	125,930,113.00
210701	Гадаад албан томилолт	00.00	40,394,100.00
210702	Дотоод албан томилолт	28,000,000.00	55,536,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	29,997,060.00	29,999,663.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,500,215.00	425,376,246.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	263,970,300.00	413,894,110.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,900,000.00	4,808,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	472,215.00	613,547.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,505,700.00	5,166,500.00
210807	Газрын төлбөр	520,000.00	762,089.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,180,398,345.18	2,693,021,668.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,090,030,139.18	2,403,776,862.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	90,368,206.00	289,244,806.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	382,959,931.17	781,793,619.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,080,053.00	115,515,775.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	60,000,000.00	46,613,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	22,818,198.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,800,200.00	20,125,332.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,279,853.00	25,958,945.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	296,879,878.17	666,277,844.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	296,879,878.17	666,277,844.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>77,402,670.00</u>	<u>128,832,400.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>77,402,670.00</u>	<u>128,832,400.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>77,402,670.00</u>	<u>128,832,400.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	77,402,670.00	128,832,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	77,402,670.00	128,832,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-77,402,670.00</u>	<u>-128,832,400.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00

145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	00.00	00.00
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	00.00	00.00
145006	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	00.00	00.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	00.00	00.00
145008	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	00.00	00.00
145009	Төрөл бүрийн хандив	00.00	00.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00	00.00
230001	Эргэж төлөгдөх зээл	00.00	00.00
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	00.00	00.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	00.00	00.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	00.00	00.00
240001	Гадаад зээлийн үндсэн төлбөр	00.00	00.00
241001	Засгийн газрын бондын үндсэн төлбөр	00.00	00.00
242001	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр	00.00	00.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	00.00	00.00
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	00.00	00.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	00.00	00.00
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	00.00	00.00
250004	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	00.00	00.00
250005	Төлсөн ногдол ашиг	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	-------	---

C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,409,638,456.59	00.00	5,507,901,462.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,409,638,456.59	00.00	5,507,901,462.66
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-377,508,959.53	00.00	-377,508,959.53
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,545,159,064.24	00.00	5,643,422,070.31
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,545,159,064.24	00.00	5,643,422,070.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	38,775,073.20	00.00	38,775,073.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,104,006,679.64	994,256,326.43	3,583,934,137.44	00.00	5,682,197,143.51
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-38,775,073.20	00.00	00.00	-38,775,073.20
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,825,434,628.40	00.00	1,825,434,628.40
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,104,006,679.64	955,481,253.23	5,409,368,765.84	00.00	7,468,856,698.71

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,238,162,900.00	3,037,466,404.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,238,162,900.00	3,037,466,404.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,092,563,800.00	2,921,950,629.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,080,607,100.00	1,025,706,127.57
210101	Үндсэн цалин	560,246,700.00	582,895,662.49
210102	Нэмэгдэл	203,849,400.00	187,934,956.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,000,000.00	37,673,800.12
210104	Урамшуулал	00.00	44,526,107.09
210105	Гэрээт ажлын хөлс	269,511,000.00	172,675,601.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,075,900.00	117,918,920.08
210201	Тэтгэврийн даатгал	91,851,800.00	83,415,576.33
210202	Тэтгэмжийн даатгал	10,805,800.00	8,348,202.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,644,600.00	6,151,571.04
210204	Ажилгүйдлийн даатгал	2,161,200.00	1,897,179.91
210205	Эрүүл мэндийн даатгал	21,612,500.00	18,106,390.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	359,218,700.00	309,823,311.18
210301	Гэрэл, цахилгаан	15,183,700.00	12,297,131.28
210302	Түлш, халаалт	321,315,000.00	283,089,421.00
210303	Цэвэр, бохир ус	22,720,000.00	14,436,758.90
2104	Хангамж, бараа материалын зардал	121,264,000.00	121,136,710.12
210401	Бичиг хэрэг	14,500,000.00	14,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	84,000,000.00	84,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,764,000.00	14,696,880.12
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	3,948,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	3,991,130.00
2105	Нормативт зардал	2,000,000.00	1,991,230.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000,000.00	1,991,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	231,430,000.00	204,562,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	113,500,000.00	113,500,000.00

210602	Тавилга	39,600,000.00	12,736,200.00
210604	Урсгал засвар	78,330,000.00	78,325,950.00
2107	Томилолт, зочны зардал	139,000,000.00	125,930,113.00
210701	Гадаад албан томилолт	48,000,000.00	40,394,100.00
210702	Дотоод албан томилолт	61,000,000.00	55,536,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	30,000,000.00	29,999,663.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,427,300.00	48,582,136.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,500,000.00	37,100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,808,000.00	4,808,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	617,300.00	613,547.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,166,500.00	5,166,500.00
210807	Газрын төлбөр	1,203,500.00	762,089.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	968540800.00	966299931.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	906,920,800.00	904,841,087.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,620,000.00	61,458,844.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145599100.00	115515775.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,599,100.00	115,515,775.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	60,000,000.00	46,613,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,818,200.00	22,818,198.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	16,613,300.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,167,600.00	20,125,332.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,000,000.00	25,958,945.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,238,162,900.00	3,153,461,522.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,228,162,900.00	3,144,162,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	3,228,162,900.00	3,144,162,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	9,298,622.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	9,298,622.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Иргэдээ дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлж, цахим технологид тулгуурласан, төрийн үйлчилгээнд шилжиж, аймгийнхаа хөгжил дэвшлийг оновчтой бодлого зохицуулалтаар хангасан ёс зүйтэй, мэргэшсэн төрийн захиргааны байгууллага байх зорилго дэвшүүлэн, үйл ажиллагаандаа өндөр мэргэшлийн, мэдрэмжтэй, хариуцлагатай, шуурхай, ил тод байх зарчмыг баримтлан ажиллах зорилтын хүрээнд дараах чиглэлийг баримтлан ажиллажээ.

Үүнд:

- ✚ Нутгийн захиргааны байгууллагын бодлого, шийдвэрт иргэдийн оролцоог хангах,
 - ✚ Байгууллагын нээлттэй, ил тод, байдлыг өргөжүүлж, төрийн албанд бүтээлч санал, санаачилга, шилдэг арга зүйг нэвтрүүлэх,
 - ✚ Байгууллагын үйлчилгээний чанар хүртээмж, албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх,
 - ✚ Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан байна.
- Хамтын ажиллагаатай Булганчууд айрагын өдөрлөг, Visit Bulgan эвент арга хэмжээнүүд, Алтаргана наадам, БНЧУ, АНУ, БНСУ, БНБУ, Унгар улсын элчин сайд, холбогдох албан тушаалтнууд албан ёсны айлчлал арга хэмжээ, гэрээ хэлэлцээр хийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллалаа.

Төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг ханган ажиллах нөхцөл боломжийг сайжруулж компьютер техник хэрэгслээр ханган ажиллаж E-Mongolia-цахим лавлагаатай болж иргэд өөрсдөө чирэгдэлгүй төрийн үйлчилгээг үзүүлж байна.

Аймгийн ЗДТГ нь 2022 онд 45 зорилтын хүрээнд 159 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 158 ажил нь хэрэгжиж 1 ажил нь хэрэгжээгүй дутуу, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 90.9 хувиар дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Архив бичиг хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийг мөрдөн ажилласан байна.

Мөн Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн захирагч нарт төсвийг хэмнэлттэй зарцуулах үүрэг өгч ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй /үр нөлөөгүй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор байгууллагын хөрөнгийн тооллогыг хугацаанд нь чанартай хийсэн эсэхийг шалгахгаар горим хэрэгжүүлсэн.

Горим сорилоор тус байгууллага нь жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/27 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр тооллогын комисс томилж ажиллуулсан боловч бараа материалын тооллогыг бүрэн хийгээгүй зөрчил илэрлээ.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ЗДТГазар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн батлаагүй, 2020 онд баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2326.2 сая төгрөгөөр буюу 41.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	11,113.3	502,839.9	491,726.6
Бараа материал	69,922.0	67,981.7	-1,941.0
Үндсэн хөрөнгө	5,562,386.5	7,398,813.9	1,836,427.4
Нийт хөрөнгө	5,643,421.8	7,969,635.5	2,326,214.0
Өр төлбөр	0	500,779.0	500,779.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,643,421.8	7,468,856.5	1,825,434.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,643,421.8	7,969,635.5	2,326,213.7

Дээрх хүснэгтээс харахад авлага 491726.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 1941.0 мянган төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө 1836427.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, нийт хөрөнгийн хэмжээ 2326214.0 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2925.5, үйл ажиллагааны орлогоос 10.0 сая төгрөгөөр нийт зарлагыг 2935.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөр өгсөн санхүүжилтийн дүнг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 09/03 тоот тогтоолоор тодотгол хийж зардлыг 488.4 сая төгрөгөөр нэмж нийт 3190.1 сая төгрөг болгон баталжээ.

Энэ нь байгууллагын барилга болон авто машины засвар үйлчилгээ, техник хэрэгсэл худалдан авах шаардлага үүссэнтэй холбогдуулж урсгал засвар, багаж тоног төхөөрөмжийн зардлыг нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 3144.2, нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар Засаг даргын мөрийн хөтөлбөрийн Хөгжлийн хөтөч дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 0.4, Архивын тасгийн ерөнхий газраас гэрээт 2 ажилтны цалинд 18.0, Батлан хамгаалах яамнаас дайчилгааны сургалтын зардалд .03, Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаны шалгалтын зардалд 4.1, Байгаль орчин аялал жуулчны яамнаас хог хаягдлыг бууруулах үйл ажиллагааны зардалд 25.8, БОАЖЯ-наас УЦУОШТ Сэлэнгэ сум 17.3, НҮБХХ-с 32.7, Айргийн өдөрлөгт Орхон аймгаас 9.0, БОАЖЯ-с 5.0 сая төгрөг, Нийгмийн хариуцлагын хүрээнд уул уурхайн компаниудаас 127.0, ЭҮТӨГ хамтран ажиллах гэрээний дагуу санхүүжилт 2000.0, урьд оны үлдэгдэл санхүүжилт 73.8, ТАЗ-ын номын үнэ 7 сумаас 1.2 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авч тайлан бүртгэлд тайлагнасан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 10.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 9.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Орлогын бүрдүүлэлт нь Архивын лавлагааны орлого 7.5, Хүний эрхийн комисс байрны түрээсийн 1.8 сая төгрөгийн орлого тус тус оржээ.

Гүйцэтгэлээр нийт 5852.8 сая төгрөгийн санхүүжилт авч 5724.0 сая төгрөгийг зарцуулж 666.3 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3037.5 сая төгрөг буюу 95.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	2048138.3	1904304.0	143834.3	92.9
2	Мэдээлэл сурталчилга	43500.0	37100.0	6400.0	85.2
3	Нийтлэг үйлчилгээ	80805.0	80805.0	0	100
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	92780.9	92697.5	83.4	99.9
5	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	22818.2	22818.2	0	100
6	Орон нутгийн нөөц хөрөнгө	892120.8	890150.0	1970.0	99.7
7	Улсын их баяр наадам	10000.0	9891.0	109.1	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 2149.1 сая төгрөгийн санхүүжилт авч цалингийн зардалд 15.8, НДШ-ийн зардалд 2.0, тавилга эд хогшил худалдан авах зардалд 24.8, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 379.1, бараа үйлчилгээний бусад зардалд 1.727.3 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/117 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 3144162.9 мянган төгрөгийн 1.5 хувиар буюу 47162.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь нийт 22.6 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Үүнд: цалингийн зардлыг 20.3, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 2.0, шуудан холбооны зардал 0.02 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан нь нийгмийн ажилтан, бэлчээр газар тариалангийн мэргэжилтний орон тоонд 2022 оны 03 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл ажилтан ажиллаагүй, зарим саруудад мэргэжлийн албан тушаалтан түр орлон /хавсран/ гүйцэтгэсэн, зарим ажилчдад хариуцлага тооцож ажилласан зэргээс шалтгаалсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд 182 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 179 мэдээг бүрэн мэдээлж 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь албан томилолтын зардлыг 1961.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт өгөхөөр шийдвэрлэв.

Шатахууны зардлыг олгохдоо тухайн авто машины нормоор тооцож олгоогүй 1476.0 мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Монгол улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Жишиг норм батлах тухай” 390 дүгээр тушаалын хавсралтад тусгагдсан “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, аймгийн ЗДТГ-ын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/56 тоот “Автомашинны шатахуун зарцуулалтын норм тогтоох тухай” захирамжийн хавсралтад заагдсан автомашинны норм гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт өгөхөөр шийдвэрлэв.

Тус байгууллагын цалингийн зардалд нарийвчлан горим хэрэгжүүлэхэд аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Б/39 тоот “Ажлаас чөлөөлөх тухай” тушаалд 2022 оны 03 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй гэж заасан байхад ажлаас халагдаж буй ажилтанд 509.8 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт өгөхөөр шийдвэрлэв.

Тус байгууллага нь шатахууны орлого зарлагын зарцуулалтыг санхүүгийн программд тайлагнадаг ч нярав сар, улирлаар шатахууны орлого, зарлагын нэгтгэсэн тайлан гаргадаггүй, шатахуун зарцуулалтын жолоочийн тооцооны хуудас болон даргын цохолт дутуу, анхан шатны баримтын бүрдэлтийг бүрэн бүрдүүлж ажилладаггүй, архивын нэгж болгон үдэж цэгцлээгүй нийт 118091.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, архивын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1-д “Байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 67981.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бараа материалын тооллого хийгээгүй, албан хаагчдын ашиглаж байгаа хөрөнгийн картаар тооллого хийгдсэн гэх боловч албан хаагчдын гарын үсэг дутуу, баримт бүрдүүлж ажилласнаар илэрхийлэгдэж байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Хичээл үйлдвэрлэлийн зардлаас томилолтын зардалд 5067.5, гадаад томилолтын зардлаас шатахууны зардалд 800.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах

үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Томилолтын зардлыг олгохдоо цаг хугацаанд нь анхан шатны баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлж ажиллаагүй, архивын баримтад үдэгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Нэг удаагийн тэтгэмжийн зардлаас эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас халагдсан ажилчдад тэтгэмж олгохдоо эмчилгээ хийлгэх болсон эмчийн дүгнэлт байхгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, өөрийн хүсэлтийг үндэслэж 2097.9 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

ЗДНХ-ийг 2022 онд 5 төрлөөр 892120.8 мянган төгрөгийн зардлыг хуваарилан баталсан ч батлагдсан хуваарийн дагуу зарцуулаагүй, шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлыг 81203.0, цэрэг татлагын зардлыг 4333.8 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

ЗДНХ-өөс аймагт 8 жил ажиллаж буй 1 иргэнд 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, мөн тусламж хүссэн иргэн бүрд туслалцаа үзүүлж байгаа нь нэг талдаа иргэдийн амьдралд дэмжлэг болж байгаа ч нөгөө талдаа төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулж цаашлаад өр авлага үүсэх эрсдэлтэй, анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж ажиллаагүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажлуудын гүйцэтгэл, зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, батлагдсан ажлуудын дагуу төсвийг зарцуулаагүй, тоног төхөөрөмж, материалыг 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр хүлээлгэн өгснөөр баримтыг үйлдсэн боловч хүлээн авсан байгууллага нь тухайн ондоо худалдан авч орлого аваагүй, байгууллагын нягтлан бодогчоор нэхэмжлэх үүсгэн 1000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн зэрэг зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан ч мэдээлсэн мэдээнүүдээс 3 мэдээ хугацаа хоцроож мэдээлсэн нь хууль тогтоомжийн заалттай бүрэн нийцэхгүй байгааг аудитын явцад цаашид хугацаа хоцроож мэдээлж ажиллахыг зөвлөлөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Аймгийн сумын ЗДТГ нь 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 03/136 тоот албан бичгээр албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	62,765.7	2	62,765.7	100
Зөвлөмж	1	0	1	0	0
Нийт дүн	3	62,765.7	3	62,765.7	100

Хэрэгжээгүй зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт дансны зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 339.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2.1 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Үүнд: Авлагын тайланд 2.1 сая төгрөгийн авлагыг дутуу илэрхийлсэн.

Аудитаар нийт 337.7 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 3 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 5 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Томилолтын зардлыг олгохдоо илүү тооцож олгосон, удирдамж, тайлангүй, АШБ-ын бүрдэлгүй 1961.0, шатахуун зарцуулалтыг нормоос илүү тооцож 1476.0, ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 509.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан зөрчлүүдэд 3 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Хичээл үйлдвэрлэлийн зардлаас томилолтын зардалд 5067.5, гадаад томилолтын зардлаас шатахууны зардалд 800.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлэн зарцуулсан, мөн санхүүгийн тайлангийн болон БМ-ын тодруулга тайлангийн 107292.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтыг нярвын шатахууны тайлагнасан тайлантай тулгахад нярав шатахууны тайланг сар бүр нэгтгэн гаргадаггүй, зөвхөн шатахуун гаргасан зардал дансаар орлого зарлагаа бүртгэсэн, 10799.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын тайланг архивын нэгж болгон үдэж цэгцлээгүй, шатахуун зарцуулалтыг жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан зөрчлүүдэд 3 албан шаардлага тогтоолоо.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Томилолтын зардлыг олгохдоо цаг хугацаанд нь анхан шатны баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлж ажиллаагүй, архивын баримт болгон үдээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Томилолтын зардлыг тооцож олгохдоо анхан шатны баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлж олгож байх.

2. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэг удаагийн тэтгэмжийн зардлаас эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн ажилчдад тэтгэмж олгохдоо эмчилгээ хийлгэх болсон эмчийн дүгнэлт байхгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, өөрийн хүсэлтийг үндэслэж 2097.9 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж ажиллах.

3. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

ЗДНХ-ийг 2022 онд 5 төрлөөр 892120.8 мянган төгрөгийн зардлыг хуваарилан баталсан ч батлагдсан хуваарийн дагуу зарцуулаагүй, шагнал урамшуулал, буцалтгүй

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тусламжийн зардлыг 81203.0, цэрэг татлагын зардлыг 4333.8 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан.

Өгсөн зөвлөмж:

ЗДНХ-ийг зарцуулахдаа батлагдсан зардлын дүнд багтаан зарцуулж байх.

4. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

ЗДНХ-өөс олгосон 50.0 сая төгрөгийн дэмжлэг, тусламжийн анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

ЗДНХ-өөс зарцуулж байгаа зарцуулалтын холбогдох анхан шатны баримтыг үнэн зөв бүрдүүлж ажиллах.

5. Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажлуудын гүйцэтгэл, зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, батлагдсан ажлуудын дагуу төсвийг зарцуулаагүй, тоног төхөөрөмж, материалыг хүлээлгэн өгснөөр баримтыг үйлдсэн боловч хүлээн авсан байгууллага нь тухайн ондоо худалдан авч орлого аваагүй, байгууллагын нягтлан бодогчоор нэхэмжлэх үүсгэн 1000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн

Өгсөн зөвлөмж:

ЗДНХ-өөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн ажлын гүйцэтгэл зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаа-гүй		Тоо	Дүн
Авлагыг дутуу илэрхийлсэн.	1	2060.9					1	2060.9				
Дүн	1	2060.9					1	2060.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Төлбөрийн акт	Албан шаардлага	/мянган төгрөгөөр/			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлс
				Үүнээс			
				Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага		

											эн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны тайланг сар бүр нэгтгэн гаргадаггүй, зөвхөн шатахуун гаргасан зардал дансаар орлого зарлагаа бүртгэсэн. Шатахуун зарцуулалтын тайланг архивын нэгж болгон үдэж цэгцлээгүй.	1	118091.7			1	118091.7						
Томилолтын зардлыг олгохдоо илүү тооцож олгосон, удирдамж, тайлангүй, АШБ-ийн бүрдэлгүй, томилолтын зардал олгосон.	1	1961.0	1	1961.0								
Шатахуун зарцуулалтыг нормоос илүү тооцож зарцуулсан.	1	1476.0	1	1476.0								
Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд илүү цалин бодож олгосон.	1	509.8	1	509.8								
Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ бараа материалын тооллого хийгээгүй.	1	67981.7			1	67981.7						
Томилолтын зардлыг олгохдоо цаг хугацаанд нь анхан шатны баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлж	1	4220.0					1	4220.0				

ажиллаагүй, архивын баримтад үдэгдээгүй байна.												
Нэг удаагийн тэтгэмжийн зардлаас эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас халагдсан ажилчдад тэтгэмж олгохдоо эмчилгээ хийлгэх болсон эмчийн дүгнэлт байхгүй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу.	1	2097.9					1	2097.9				
ЗДНХ-ийг баталсан зардлаар зарцуулаагүй, хэтрүүлж зарцуулсан.	1	85536.8					1	85536.8				
ЗДНХ-өөс зарцуулсан хөрөнгийн анхан шатны баримтын бүрдлийг үнэн зөв бүрдүүлж ажиллаагүй.	1	50000.0					1	50000.0				
ЗДНХ-өөс хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хийгээгүй.	1	0					1	0				
Дүн	9	331874.9	3	3946.8	2	186073.4	5	141854.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зардал хооронд шилжүүлэн зарцуулсан.	1	5867.5			1	5867.5		
Дүн	1	5867.5			1	5867.5		
Нийт дүн	1	5867.5			1	5867.5		